



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Овоотел ХХК-ийн “Овоотел” зочид буудлын 17/322, Цайны Зам Трейд ХХК-ийн “Анлантис” зочид буудлын 18/26, Ирмүүн дэлгэрэх ХХК “Хэрлэн” зочид буудлын 18/40, Зүчи хотел ХХК-ийн “Зүчи” зочид буудлын 18/36, Одод ХХК-ийн “Вояж” зочид буудлын 18/07, Юү эс эй энд би ХХК-ийн “Оргил” зочид буудлын 18/04, Дөрвөн нуур ХХК-ийн “Дөрвөн нуур” зочид буудлын 18/45, Ортэ ХХК-ийн “Сан” дэн буудлын 17/325, Он энд он ХХК “Ю-би” дэн буудлын 17/264, Азэ трейдинг ХХК “Улз” дэн буудлын 18/22, Дархан цогт ХХК “Дөл” дэн буудлын 17/281 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.


1150500054

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага, жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Х.Содномдэмбэрэл/-д үүрэг болгосугай.

Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2019 оны 01 сарын 28 өдрийн
А/04 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.01.28

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Овоотел ХХК	5314275	Овоотел	БГД-ийн, 19-р хороо Л.Энэбишийн өргөн чөлөө 71
2	Цайны зам трейд ХХК	2045893	Атлантис	ХУД-ийн, 2-р хороо, 19-р хороолол, То-вангийн гудамжны 25/1
3	Ирмүүн дэлгэрэх ХХК	4551125	Хэрлэн	БГД-ийн 1-р хороо, Нацагдоржийн гудамж 23А тоот
4	Палас ХХК	2038526	Зүчи	ХУД-ийн 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 25а
5	Одод ХХК	2066505	Вояж	БГД-ийн, 3-р хороо, Нарны зам-60
6	Юү эс эй энд би ХХК	5091543	Оргил	ХУД-ийн, 11-р хороо, Дайчдын хөшөө 1-10
7	Дөрвөн нуур ХХК	2085658	Дөрвөн нуур	БГД-ийн, 3-р хороо, Замчдын гудамж 94
8	Мон-туул ХХК	2112752	Жениус	БГД-ийн 1-р хороо, 2-р хороолол, Хатанбаатар Магсаржавын гудамж 6-В тоот

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2019 оны 01 сарын 28 өдрийн
А/04 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.01.28

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ортэ ХХК	5034442	Сан	БЗД-ийн 7-р хороо, Доржийн гудамж –9
2	Он энд он ХХК	2562197	Ю-би	ЧД-ийн 1-р хороо, Бага тойруу 41/21
3	Азэ трейдинг ХХК	2047241	Улз	ЧД-ийн 4-р хороо, Бага тойруу 20/1
4	Дархан цогт ХХК	5000165	Дөл	СХД-ийн, 11-р хороо, АОС, 3-2
5	Уан степ ХХК	2829762	Зебра	БГД-ийн, 9-р хороо, Хасбаатарын гудамж 23/5